

06 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Төрийн үйлчилгээний чиглэлээр: "НУТГИЙН ЗАЛУУЧУУД" цахим чуулган 2021.06.25 ны өдөр зохион байгуулагдсан. Тус чуулганд сумын залуучуудын төлөөлөл 31 залуучууд оролцсон. Нутгийн залуучууд чуулганы төгсгөлд Залуучуудын үзэл бодол, санал хүсэлтийг сонсож залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын удирдлагууд хамтран ажиллах "САНАМЖ БИЧИГ"-т гарын үсэг зурлаа.

Анхан шатанд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй гардан ажилладаг сум, багийн Хамтарсан багийн цаасаар хийдэг ажил цахимжиж эхэллээ.

☑ ХНХЯ болон НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, салбар дундын уялдаа, хүртээмжтэй хариу арга хэмжээг дэмжих төслийн хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг эрчимжүүлэх зорилгоор Хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээ, кейс менежментийн систем 2021-07-01 ний өдрөөс ашиглалтанд орох гэж байна. ☑ Анхан шатанд ажиллаж буй Сүхбаатар аймгийн бүх сумдын 22 ХАМТАРСАН БАГ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хамтарсан баг"-ийн нарийн бичиг тус бүрд

☑ Tablet -keis, үзэг, ком

☑ Fingerprint Scanner- хурууны хээ уншигч

☑ Converter - хөрвүүлэгч

☑ Sim kard, дата дугаар

нийт 1,365,200 төгрөгний тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснийг авлаа.

Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоол "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"-ын хэрэгжилтийн талаарх чанарын мэдээллийн судалгаар 2сурагчийн мэдээлэл ирж үнэлгээ хийгдэж кейс нээж нэг сурагчийн кейсийг шийдвэрлсэн уг дансыг 18нас хүртэл хугацаатай хадгаламж болгож өглөө.

Төсөвт-5 байгууллагын эцэг эхийн зөвлөл албан байгууллагын ажилчдынхаа нийт 318 хүүхэд 4705.0 мян төгрөгний "бэлэг" гардуулав. Хүүхдүүдийг Гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар хяналт тавьж ажилладаг. Багш нар "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" ийн арга хэмжээг "НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН" ийн хүрээнд зохион байгуулж анги бүлэг бүрийнхээ цахим хуудсаар дамжуулан эцэг эх хүүхэд багачууддаа зориулсан видео шторк хийж хамтран ажиллаа.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

6 сарын1-5, 5 дугаар сарын өрийн мэдээ болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарган шилэн дансанд шивж байршуулан ажилласан. Хагас жилийн мал тооллогын санхүүжилт болох 1386015 төгрөгийн зардалыг тоологч болон ахлагч тоологчид олгосон.

6 сарын 20 ноос 30 -ны хооронд төсөвт байгууллагуудын тогтмол зардал болон бусад холбогдох гүйлгээг хийж ажилласан. Сар бүрийн 17-ноос 19-ны хооронд бараа,ахуйн хэрэглээний үнийн мэдээг Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтэст явуулсан.

Ноосны урамшуулал авах иргэдийн 487 нэхэмжлэх,малын тоо толгой албан татварын 149 нэхэмжлэл үүсгэсэн. АТӨЯХАТ-ын албан татварыг 162 иргэнээр төлүүлсэн.Төсөвт

байгууллагын санхүүгийн хагас жилийн тайлан болон татварын тайлангуудыг хийж гүйцэтгэж байна.

Улсын төсөв 2,0 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн 17 ортой эмнэлэгийн барилгыг шинээр барих ажлыг тусгуулсан. ЭМТ-ийн барилгын ажлын тендер зарлагдсан Хөх хайрхан трейд ХХК тендерт шалгарч барилгын ажил эхлээд байна. Сумын төвд 400м хатуу хучилттай засмал зам барих ажлын тендерийг зарлаж “Ханан салхит” ХХК шалгарч 2021 оны 05 сарын 03 нд гэрээг байгуулан ОНХС-ын санхүүжилт 100,0 сая төгрөгийг шилжүүлэн засмал замын ажил хийгдэж эхлээд байна.

Гурав: Нийгмийн бодлогын хүрээнд:

ЕБС: Ерөнхий Боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдад боловсролын баримт бичиг гардуулах үйл ажиллагааг энэ оны 06 дугаар сарын 02-ны өдөр 11:00 цагт, 12-р ангийн сурагчдад гэрчилгээ гардуулах үйл ажиллагааг 06 сарын 03-ны өдрийн 10:00 цагт тус тус зохион байгуулсан бөгөөд тус үйл ажиллагаанаас өмнө нэгдсэн ариутгал хийж, гэрчилгээ гардуулах үеэр багш сурагчдыг хоорондын зайг бариулж халдвар хамгааллын дэглэмийг чанд баримталж ажилласан.

Боловсролын баримт бичиг гардан авсны баяр, хүлээн авалт, аялал зугаалга зохион байгуулахгүй байх, зохион байгуулсан тохиолдолд хатуу арга хэмжээ авахыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж төгсөх ангийн багш сурагчид болон эцэг эхчүүдэд танилцуулж, зөвлөгөө зөвлөмжүүдийг хүргэсэн. ЕБС-ийн 12-р ангийн сурагчдад 06 сарын 17-ны өдөр хүртэл халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ЭЕШ-ын давтлагыг танхимаар өгсөн. Сургуулийн хуучин хашааг буулгаж нийт эзэмшлийн талбайгаа шинэчлэн хашаажуулсан.. Мөн дотуур байрын хуучин хашаануудыг буулгаж тус хашааны төмрөөр шинэ хайсан хашаа гагнаж дотуур байрын орчныг бүрэн хашаажуулж засвар хийсэн. Бүрэнцогт багийн харъяат Аймгийн сайн малчин Мөнхдоржийн гэр бүлийн зүгээс тус сургуулийн Байгалийн ухааны заах аргын нэгдлийн багш нарын өрөөг шинээр тохижуулж өгөхөөр болсон ба тус танхимыг шинэчлэн тохижуулах барилгын болон дотоод засал чимэглэлийн материалуудыг бэлэн болгоод байна.

Сургуулийн гадна талбайн тохижилт, цэцэгжүүлэлтийг шинэчлэх зорилгоор цэцгийн мандал хийх зориулалт бүхий 20 ширхэг эко модон торх хийж сургуулийн эзэмшлийн талбайд байрлуулсан бөгөөд тус сургуулийн багш ажилчид 20 багт хуваагдан баг тус бүр нэг цэцгийн мандлыг хариуцан ажиллаж эхлээд байна. Сургалтын чанарыг сайжруулах зорилгоор БСШУ-ны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021.02.01-ний өдрийн А/35/А/10/1 тоот тушаалын дагуу тус сургуулийн дэргэдэх 5 хүний бүрэлдэхүүнтэй “Ажлын үнэлгээний баг”-ийг сургуулийн захирлын А/12 тоот тушаалаар томилон ажиллуулсан бөгөөд тус үнэлгээний баг нь нийт багш нарын үйл ажиллагаанд нэг бүрчлэн хяналт шалгалт үнэлгээ хийж, шаардлага хангаж хангалттай үнэлгээ авсан 17 багшид “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу ур чадварын нэмэгдэл олгосон.

Тус сургуулийн 17 нас хүрсэн сурагчдыг энэ сараас эхлэн эцэг эхчүүдийг нь байлцуулан вакцинжуулалтад хамруулж эхлээд байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2021 оны 06 сарын 30 -ны байдлаар 24 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 21 насанд хүрэгчид, 3 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Хүнд хүндэвтэр 2 хүн хэвтсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэг 969 байна. Ковид19 вакцины 1,2 тунг өдөр бүр хийж мэдээг ЭМГазар болон бусад газарт мэдээлж байна. Нийт 3138 хүн вакцинд хамрагдахаас 1-р тунд 2688 хүн, 2-р тунд 2513 хүн хамрагдаж нийт хамрагдалт 85,6 хувь байна. Комирнэти вакцинд зорилтот бүлгийн 64 хүн, 12-18 насны 218 хүүхэд хамрагдаад байна. 6 сарын байдлаар Сүрьеэгийн хяналтын эмчилгээнд 2 өвчтөн сумын ЭМТөвийн хяналтанд эмчлэгдэж сорьцын шинжилгээгээр үргэлжлэх шатны эмчилгээг үргэлжлүүлэхээр болсон. Хяналтын шатны эмчилгээ амжилттай дууссан.Ковид19 цар тахалтай холбоотой мэдээлэл сургалт сурталчилгааг зорилтот бүлэгт болон цахимаар иргэдэд мэдээллийг хүргэж байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2120 гарын авлага зөвлөмжийг айл өрхөөр болон ААНэгжээр тараасан. ЭМТөвийн цахим хаягаар иргэдэд 184 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж нийт 1023 хүний хандалттай байна. Мөн ЭМГазар болон ЭМЯ-ны мэдээллийг өдөр бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна.

Гэрийн ажиглалтанд 6 сард нийт 92 хүн тандалтанд байсан. Мэдээг өдөр бүр ЭМГ болон мэргэжлийн хяналтын газарт мэдээлж байсан. Мөн вакцины 2 тунгаа хийлгээд 14 хоносон болон 72 цагтаа буцах иргэдэд халдвар хамгааллын дэглэмээ сайн мөрдөж байхыг зөвлөж байна. ЭМТөвийн нэг удаагийн эм эмнэлгийн хэрэгслийн орлого зарлагыг burtgel.mn программд шивж мэдээллийг оруулж байна.Түргэн тусламжийн дуудлага 34 ирснээс алсын дуудлага - 5, ойрын дуудлага 29 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Дөрөв: Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр:

Малжуулах” хөтөлбөрт 3-р багийн иргэн Б.Очирпүрэв 5,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдсан. “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 1-р багийн иргэн Ж.Долгорсүрэн Арьс ширэн эдлэл-ээр 2,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх” хөтөлбөрийн хүрээнд 4-р багийн иргэн Н.Пүрэвдорж Модон эдлэлээр 5,0 сая төгрөгийн төсөл дэмжигдээд байна. “Нийтийг хамарсан ажил”-аар Хог цэвэрлэгээгээр 10 иргэн 2,8 сая төгрөгний санхүүгийн дэмжлэгт хамрагдсан. ОНОТХҮ-ний төсөлд 3 өрх 1,0 сая төгрөг, ЗДТгазар - 4 шинэ ажлын байр бий болгосон. СХСангийн төсөлд 1 иргэн 20,0 сая төгрөг 3 шинэ ажлын байр , ХЭДСангийн төсөлд 6 иргэн хамрагдсан. Нийт 16 иргэн хамрагдсан байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр-85 иргэн, Одон-425, Насны хишиг-199, Цалинтай ээж -249, Жирэмсэн нярайн-28, зэрэг нийт 986 иргэнийг дансжуулж цахимд бүртгээд байна

Тав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Сумын засаг даргын 2021-06-14-ны өдрийн а/90 тоот захирамжын дагуу 5 багт 5 хэсэг гарч хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж түүвэр судалгаанд 178 өрх хамрагдаж ШТС-д 704,6 мян төгрөг,тоологчийн зардал-357,4 мян,ахлагч нарын зардалд-32,5 мян,шивэлтийн зардалд-64,5 мян,холбооны зардал-10,0 мян төгрөг нийт-1386,0 сая

төгрөг зарцуулсан байна.Түүвэр судалгаанд хамрагдсан 178 өрхийн малыг 5-н төрлөөр нь авч үзвэл:

Тэмээ-216, Адуу-1010, Үхэр-8324, Хонь-58984, Ямаа-35404 Бүгд-130028 толгой мал тоолж бүртгэл мэдээлэлийн санд хамрууллаа,

Сумын ИТХ-ын тогтоолоор төмс хүнсний ногоо тариалах сонирхолтой 20 иргэнд 2 га талбай олгож төмс хүнсний тариалсан байна, ХХААГазраас хөнгөлөлтэй үнээр 40 кг төл сонгины үр, 20 кг сармисны үрийг иргэд нийлүүлсэн. ДХХ-н 222 л, сахуу- 51 л, орон нутгийн вакцин татан авч 5 хувийн хэвшлийн мал эмнэлэгт хувиарь хийлээ.

Мал эмнэлгийн цахим системд гаднаас отор нүүдлээр ирсэн 7 өрхийн үхэр 17, адуу 48,үржлийн зориулалтаар 8 өрхийн адуу 29, үхэр 8, ямаа1 ирсэн байна.

6 сард цахим гэрчилгээ 402 ш бичиж адууны мах -15885 кг, үхэрийн мах 19238 кг, хонины мах 41703 кг, ямааны мах 14415 кг, тэмээний мах 1150 кг бичсэнг хянаж баталгаажуулалт хийлээ. Амьд мал адуу 356, үхэр 198, хонь 3215, ямаа 1138, тэмээ 3 малд гарал үүслийн гэрчилгээ бичсэн. Зүүн бүсийн 3 аймгаа шүлхий, бог малын мялзан өвчний тандалт шинжилгээд 1 дүгээр багаас 2 өрх сонгогдож үхэр 8, хонь 12, ямаа 12, нийт 32 малаас цус авч ийлдэс ялгаж аймагт хүргэж өгөх ажил үлдсэн.

Зургаа : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Сумын хөгжлийн төлөвлөгөөг хийх ажлын тендер шалгаруулалтыг аймагт зохион байгуулж “Инженер геодези ХХК” шалгарч сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлээд байна. Сумаас гарах суурь судалгаа болон дэлгэрэнгүй судалгаа, иргэдээс санал асуулгыг цаасаар болон цахимаар авч тус компани руу илгээсэн. Тус компани нь 2 хоног суманд ажиллаж дроноор хэмжилт зураглал хийсэн. Нийтийг хамарсан “Хог цэвэрлэгээ”-ний төслөөр 2020.06.14-нөөс эхлэн 10 хонгийн хугацаанд сум тойрсон 3кмт эзэнгүй хаягдсан, хогийн цэг үүссэн болон сэг зэм ахуйн хог хаягдлыг 10-н ажилгүй иргэдээр цэвэрлэгээг хийлгэж ажиллалаа. Хог зөөх машинд 10 хонгийн 100л түлш буюу 242000төгрөг, хяналт шалгалтаар А-92 30л 46500 төгрөг нийт 288500 төгрөгийн шатах тослох материалын зардал гарсан. Үүнийг ЗДТГ-аас шатах тослох материалын зардалыг хариуцсан.

Уг ажилд Мөнххаан сумын ажилгүй, ажил хайж буй 10 иргэнийг 10 хоног түр ажлын байраар ханган цалинжуулан ажилласан.

Энэхүү ажилд ажилласан 10 ажилчдын цалинг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас санхүүжүүлсэн. Мөн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар өгч ажиллалаа. ЗДТГ-аас өдөр бүр 10 ширхэг бээлий, маск тараан өгсөн.

